

ТАНИЛЦУУЛГА

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Ардчилсан Үндсэн хууль буюу 1992 оны Үндсэн хуулийн зорилго, зарчим, агуулгад нийцүүлж 1995 онд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг баталсан. Энэ хууль нь байгаль орчны салбарын суурь хууль юм.

Мөн 1998 оноос хойш 24 удаа нэмэлт, өөрчлөлт орж улам баяжуулж, хийдэл, давхардал, зөрчлийг нь арилгасаар ирсэн.

Харин Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг 1998 онд анх баталж, 2012 онд шинэчилсэн найруулга хийж дахин баталсан. Энэ хуулинд 2012 оноос хойш 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Байгаль орчны асуудал нь дэлхийн хэмжээний асуудал болсон учраас дэлхийн улс орнуудын сайн жишгийг монголд нутагшуулахын тулд Байгаль орчин, аялал жуулчлалын яам өнгөрсөн жилүүдэд салбарын хууль тогтоомжоо тогтмол шинэчилсээр ирсэн.

Гэвч байгалийн баялгийн тэгш хувиарлалт, түүний ашгийг ард түмэнд хүргэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудал олон жил нийгмийн томоохон сэдэв болсоор ирсэн ба энэ нь үндэсний аюулгүй байдлын асуудал ч болдог байна.

Монгол Улсын эдийн засгийн томоохон хэсгийг уул уурхайн салбар бүрдүүлж байгаа учраас байгаль орчны асуудал маш эмзэг сэдэв болсон. Байгаль орчны асуудал буюу экологийн аюулгүй байдлын асуудал, иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлын асуудлыг Үндсэн хуулиараа баталгаажуулах нь төрийн үүрэг юм.

Иймд иргэд, олон нийтийн байгууллага, төр засгийн зүгээс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж иргэдийн эрхийг улам бататгах асуудлыг олон жил ярьж хэлэлцэж ирсэний үр дүнд Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан.

Энэ өөрчлөлтөөр Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн хоёр дах хэсэгт “...Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй...” гэсэн зохицуулалт орсон.

Үүний дагуу Засгийн газар 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр “Төлөвлөгөө батлах тухай” 66 дугаар тогтоолын хавсралтаар Үндсэн хуулийн зургадугаар зүйлд орсон дээрх зохицуулалтыг Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд оруулахаар баталсан.

Үүний дагуу энэхүү хоёр хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.18-д Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3.4.1, 3.4.3-т заасан асуудлаар боловсруулсан хууль тогтоомжийн төсөл боловсруулахад холбогдох судалгаа, тооцоо, үр нөлөөний судалгаа хийхгүй гэж заасан.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.3-д “...иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал...” нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болно гэж заасан.

Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлт нь Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн энэхүү заалтыг улам баталгаажуулж өгсөн юм.

---000---

БАТЛАВ:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Д.САРАНГЭРЭЛ

БАТЛАВ:

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Х.НЯМБААТАР

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ, БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Байгаль орчны асуудал нь дэлхийн хэмжээний асуудал болсон учраас дэлхийн улс орнуудын сайн жишгийг монголд нутагшуулахын тулд Байгаль орчин, аялал жуулчлалын яам өнгөрсөн жилүүдэд салбарын хууль тогтоомжоо тогтмол шинэчилсээр ирсэн.

Гэвч байгалийн баялгийн тэгш хувиарлалт, түүний ашгийг ард түмэнд хүргэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудал олон жил нийгмийн томоохон сэдэв болсоор байна.

Монгол Улсын эдийн засгийн томоохон хэсгийг уул уурхайн салбар бүрдүүлж байгаа учраас байгаль орчны асуудал маш эмзэг сэдэв болсон.

Иймд иргэд, олон нийтийн байгууллага, төр засгийн зүгээс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж иргэдийн эрхийг улам бататгах асуудлыг олон жил ярьж хэлэлцэж ирсэний үр дүнд Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан.

Энэ өөрчлөлтөөр Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн хоёр дах хэсэгт “...Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй...” гэсэн зохицуулалт орсон.

Үүний дагуу Засгийн газар 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр “Төлөвлөгөө батлах тухай” 66 дугаар тогтоолын хавсралтаар Үндсэн хуулийн зургадугаар зүйлд орсон дээрх зохицуулалтыг Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд оруулахаар баталсан.

1.1.Хууль зүйн үндэслэл:

Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн хоёр дах хэсэгт “...Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй...” гэж, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.3-д “...иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал...” нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болно гэж тус тус заасан.

Үүний дагуу Засгийн газар 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр “Төлөвлөгөө батлах тухай” 66 дугаар тогтоолын хавсралтаар Үндсэн хуулийн зургадугаар зүйлд орсон дээрх зохицуулалтыг Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд оруулахаар баталсан.

1.2. Практик үндэслэл:

Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхийг бататгах нь төрийн үндсэн үүрэг юм.

Хоёр. Хуулийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

2.1. Хуулийн зорилго:

Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрхийг хамгаалах, салбар хуулиар иргэний эрхийг тунхаглан хэрэгжүүлэх.

2.2. Хуулийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь 2 зүйл, 3 хэсгээс, Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь мөн 2 зүйл 3 хэсгээс бүрдэж байна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараах нийгэм, эдийн засгийн үр дагавар.

Хуулийн төсөл батлагдсанаар Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрхийг хамгаалах механизм бүрдэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улс орон даяар хянах, мөрдүүлэх ажилд дэвшил гарч, төр иргэний хоорон дахь хамтын ажиллагаа, уяалдаа сайжирна.

Дөрөв. Хуулийн төсөл батлагдсаны дараа уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон цаашид боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар

Хуулийн төсөл батлагдсаны дараа бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орохгүй болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020.05.26.

Улаанбаатар хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй.

1/3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 15 дахь заалт

“3.2.15.Байгаль орчны нөлөөлөл” гэж байгаль орчин, түүний баялгийг ашигласны улмаас бий болсон өөрчлөлт, хувьсал болон хүн, амьтны амьдрах орчин үзүүлэх нөлөөлөлийг;

2/4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг.

4.1.7.тухайн нутаг дэвсгэртээ газрын хэвлийн баялгийг ашигласнаас үүдэх байгаль орчны нөлөөллийг мэдэх, энэ талаар харьяалах Засаг даргаас мэдээлэл авах.”

2/16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх.

16.2.11.харьяалах нутаг дэвсгэртээ газрын хэвлийн баялгийг ашигласнаас үүдэх байгаль орчны нөлөөллийн талаар орон нутгийн иргэдэд хагас жил тутам мэдээлэл өгөх, мэдээллээр хангах, байгаль орчны мэдээллийн санд холбогдох мэдээллийг нээлттэй оруулах”

3/17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“17 дугаар зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх.

17.2.11.харьяалах нутаг дэвсгэртээ газрын хэвлийн баялгийг ашигласнаас үүдэх байгаль орчны нөлөөллийн талаар орон нутгийн иргэдэд хагас жил тутам мэдээлэл өгөх, мэдээллээр хангах, байгаль орчны мэдээллийн санд холбогдох мэдээллийг нээлттэй оруулах”

2 дугаар зүйл: Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020.05.26.

Улаанбаатар хот

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд дор дурдсан заалт нэмсүгэй.

1/14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг:

“14 дүгээр зүйл. Стратегийн үнэлгээнд хамрагдах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулсан байгууллага болон төсөл хэрэгжүүлэгч дараах үүрэг хүлээнэ.

14.1.4. газрын хэвлийн баялгийг ашигласнаас үүдэх байгаль орчны нөлөөллийн талаар орон нутгийн иргэдэд мэдээлэл өгөх, мэдээллээр хангах ажлыг хагас жил тутам зохион байгуулах”

2/18 дугаар зүйл. Нөлөөллийн үнэлгээний үйл ажиллагааны олон нийтийн оролцоо.

“18.6. иргэд тухайн нутаг дэвсгэрт газрын хэвлийн баялгийг ашигласнаас үүдэх байгаль орчны нөлөөллийн талаар мэдээлэл авах санал, хүсэлтээ харьяа Засаг дарга, төсөл хэрэгжүүлэгчид гаргах бөгөөд иргэдийн энэхүү санал, хүсэлтийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

2 дугаар зүйл: Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР